

УЛААНБААТАР ХОТЫН НАЛАЙХ ДҮҮРГИЙН 1-Р ХОРООНЫ НУТАГТ ОРШИХ
“БАЯН-АМ” НЭРТЭЙ “ДАЙРАГНЫ ОРД” ТӨСЛИЙН 2022 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

(Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн дугаар: 18/М011)
(Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар: 4490886)

Хянасан:

БОАЖЯамны ХБОБНУГ-ын мэргэжилтэн _____

Биелэлтийг тайлагнасан:

“Амьдралын илч” ХХК-ийн захирал _____ Ж.Амьдралхүү

“Амьдралын илч” ХХК-ийн Менежер _____ С.Дэлгэрдалай

2022 он

ГАРЧИГ

1. 2022 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	6
2. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт.....	9
3. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	9
4. Нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө.....	9
5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө	9
6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	10
<i>Ажилчдын аюулгүй байдлыг хангах.....</i>	12
<i>Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа болон галын аюултай тэмцэх талаар</i>	12
<i>Аюулгүй ажиллагаа</i>	13
Аваар устгах арга хэмжээ	13
7. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	13
8. Байгаль орчныг хамгаалах удирдлага зохион байгуулалт.....	15
9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт	16


1. 2022 ОНЫ УУЛЫН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төслийн ангилал: Улаанбаатар хотын Налайх дүүргийн 1-р хорооны нутагт орших “Баян ам” нэртэй 27.3 га талбай бүхий 18/M011 дугаартай тусгай зөвшөөрлөөр жилд 150.0 мян.м³ түгээмэл тархацтай ашигт малтмал болох дайргыг ил аргаар олборлож, жилд 88479.56 м² талбайн хөрс хуулж, 180 хоног, 2 ээлжээр, нийт 44 ажилчидтай үйл ажиллагаагаа явуулж байна. Тус дайрганы орд нь хөрс хуулалт харьцангуй багатай тул хөрсний овоолго бага үүснэ. Ил уурхайн баруун талд дунджаар 150-300 м зайд гадаад овоолго үүсгэж шимт хөрсний овоолгын эзэлхүүн 31.9 мян.м³ байна.

Дайрганы ордыг ил аргаар олборлох төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн мэдээлэл:

Хүснэгт 1. “Амьдралын илч” ХХК-ийн мэдээлэл

ААНэгжийн нэр	Улсын бүртгэлийн дугаар	Үйл ажиллагааны чиглэл	ААН-ийн хаяг, байршил
Амьдралын илч ХХК	2911003058	Уул уурхайн тоног төхөөрөмжийн худалдаа	Налайх, 1-р хороо, Баянзүрхийн, Өвөршандын 2-4-4 тоот



Зураг 1. Төсөл хэрэгжих газрын байршил



Зураг 2. Агаар сансрын зураг

Уурхайн барилга, байгууламж: Захиргаа, ил уурхай, бутлан ангилах боловсруулах хэсэг, засвар, механикийн цех

Техник, тоног төхөөрөмжүүд: САТ-320С маркийн эксковатор, HOWO маркийн өөрөө буулгагч автосамосвал

2022 оны Уулын ажил: “Баян-Ам” дайрганы ордын ашиглалтын үндсэн үйл ажиллагаа нь:

- Үржил шимт өнгөн хөрс хуулах
- Өрөмдлөг тэсэлгээний ажил хийх
- Хөрс хуулах
- Дайрга олборлох
- Олборлосон дайргыг бутлах төхөөрөмжийн ойролцоо тээвэрлэн буулгах
- Бутлагдсан дайргыг шигших
- Боловсруулагдсан бүтээгдэхүүнийг хэрэглэгчдэд нийлүүлэх
- Хөрсний овоолго, тэгшлэлтийн ажил
- Техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажил.

Уурхайн бэлтгэл ажлаар дараахь ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

- Ажилчдын орон сууц барих, суурин байгуулах
- Тээврийн хэрэгсэл зорчих зам бэлтгэх
- Сэлбэг хэрэгсэл, шатахуун агуулах сав хадгалах байр болон талбай байрлуулах
- Уурхайн талбайг үерээс хамгаалах далан, шуудуу татах
- Бутлах, шигших тоног төхөөрөмжийг угсрах, байрлуулах



Усан хангамж: Уурхайн нь технологийн хэрэгцээнд ус ашиглахгүй. Уурхайд 35-44 хүн ажиллах ба хоногт 1.75-2.2 м², жилд 180 хоногт 315-396 м³ усыг унд ахуйн хэрэглээнд ашиглана. Унд ахуйн усыг Налайхын ус түгээгүүрийн худгаас зөөврөөр хангадаг.


Цахилгаан хангамж: Уурхайн цахилгааны гол хэрэглэгчид нь өрмийн машин, 1 ба 2-р шатны бутлуур, шигшигч, конвейр, засварын цех, гэрэлтүүлэг бобусад жижиг хэрэглэгчид байна. Эдгээр цахилгаан хэрэглэгчдийг уурхайгаас 1 км зайд өнгөрөх 35кВ-ын өндөр хүчдэлээс салгасан агаарын шугам татан эрчим хүчээр хангахаар тооцсон болно.

1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
НЭГ. АГААР ОРЧИН ЧАНАР		
Агаар орчинд тоосжилт үүсэх Дуу шуугиан	Дотоод тээврийн замаас тоосжилт үүсэлтийг бууруулахын тулд усалгаа хийх	Уурхайн дотоод тээврийн зам дагуу тоосжилтоос хамгаалах усалгааг хуурайшилт ихтэй хавар, намрын улиралд 1тн-ын багтаамжтай саваар зөөвөрлөн, сард 8 удаа, нийтдээ 40 удаагийн усалгаа хийж, 1 удаадаа 3тн ус, нийт 72.0 тн ус зам талбай услахад зарцуулсан. 1 удаагийн усалгаа шороон зам 500*9м /ойролцоогоор замын өргөн/ 4500м ² талбайг услахад 9000 л буюу 9.0 тн ус шаардагдана. /1м ² талбай услахад 2л ус шаардагдана./ (БОНХАЖ-ын сайдын 2015 оны А/301-р тушаалын 13-р хавсралтын 7-г үндэслэн усны нормыг тооцов.)
	Тэсэлгээг тодорхой хуваарийн дагуу хийх, тэсэлгээ хийх үеийн салхины хурд, чиглэлийг харгалзан үзэх, хүчтэй салхитай өдөр тэсэлгээний ажил хийхгүй байх	2022 онд тэсэлгээний ажил хийгдээгүй.
	Дайрга бутлах болон ангилах хэсгээс орчинд тоосжилт үүсэхээс сэргийлж резинэн болон даавуун хөшиг татах.	Дайрга бутлах болон ангилах ажлууд хийж гүйцэтгэх үед төхөөрөмжинд даавуун хөшиг татаж, уурхайн үйл ажиллагааны туршид талбайд ажиллаж буй уурхайн ажилчдад “М 1200 Хагас нүүрийн амьсгалын баг” тоосноос хамгаалах зориулалттай маскаар хангаж ажилласан.
ХОЁР. ХӨРСӨН БҮРХЭВЧ		
Газрын гадарга хөрс эвдрэл, элэгдэлд орох	Дотоод тээврийн 1км орчим замыг тэгшлэн, сайжруулсан шороон зам болгох, 2 жил тутамд сэргээн засах.	ТЭЗҮ-д тусгагдсаны дагуу дотоод тээврийн 500м авто замыг байгуулж, хайрган хучилт хийж сйажруулсан ба тээвэрлэлтийн зам дагуу чиглэл заасан тэмдэг байршуулан, 1 чиглэлийн маршрутаар тээвэрлэлт хийж гүйцэтгэж байна.

	<p>Зөвхөн тогтсон замаар тээврийн хэрэгслийг явуулах, бусад газарт хориглосон тэмдэг тэмдэглэгээ байршуулах</p>	<p>Уурхайн замуудад хурд сааруулах болон хориглосон тэмдэг байршуулсан.</p>	
	<p>Шатах тослох материалыг ил задгай хөрсөнд шууд хаяхгүй байх, засвар үйлчилгээг зориулалтын цэгт хийдэг байх</p>	<p>Машин механизмын засвар үйчилгээг засварын цехэд хийж гүйцэтгэдэг ба шатах тослох материалын үлдэгдэлийг тагтай тусгай саванд хийжтусгай байгуулсан цэгт хадгалдаг.</p>	
ДӨРӨВ. УРГАМЛИАН НӨМРӨГ			
<p>Хөрсний овоолгод үе шаттайгаар нөхөн сэргээлт хийх буюу нэг болон олон наст ургамал тарих</p>	<p>Суулгац худалдан авах Мод бут тарих, ургамалжуулах Мониторинг хийх</p>	<p>Хөрөнгө оруулалтын хүндрэлтэй байдлаас шалтгаалан мод тарих ажлыг 2023 онд хийхээр төлөвлөж байна.</p>	
ТАВ.ЭРЧИМ ХҮЧНИЙ ХЭМНЭЛТ			
<p>Цахилгаан эрчим хүчний хэт их хэрэглээ</p>	<p>Цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй тоног төхөөрөмж сонгож хэрэглэх Дотор гэрэлтүүлгийг ЛЕД чийдэн сонгох</p>	<p>Уурхайн кемпэд ашиглагдаж байгаа гэрлүүдийг ЛЕД гэрлээр бүрэн хангасан</p>	<p>Ажилчдын гэр, хоолны газар, гадаах гэрэлтүүлгийг ЛЕД гэрлээр хангасан.</p>
ЗУРГАА. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ			
<p>Ахуйн хэрэглээний хог хаягдал Буруу хадгалсан хог хаягдал түүний эх үүсвэрээс үнэрийн бохирдол гарах</p>	<p>Энгийн хатуу хог хаягдлыг ангилан ялгаж, эмх цэгцтэй хадгалах хогийн сав байршуулах. Уурхайн ажилчдад зориулан хог хаягдлын ангилан ялгаж хаях талаар заавар зөвлөмж бүхий зурагт хуудас, зөвлөмжүүдийг байршуулах</p>	<p>Уурхайн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг ахуйн болон аюултай хог хаягдал гэж ангилан түр хадгалах хогийн цэг байгуулсан. Мөн 2022.06.01-нд “Тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ-тэй хог хаягдлыг ачиж тээвэрлэх гэрээ байгуулан ажиллаж байна. (Гэрээг хавсралтаар хавсаргав.)</p>	
<p>Хог хаягдал, ариун цэврийн байгууламж орчны</p>	<p>Ажилчдын ариун цэврийн хэрэглээнд зөврийн Био-00-г ашиглах</p>	<p>“MNS 5924 : 2015 Нүхэн жорлон, угаадасны нүх.Техникийн шаардлага” стандартын дагуу ариун цэврийн байгууламжийг цементээр доторлон, агааржуулалтын хоолойтой, борооны ус орохоос сэргийлсэн сендвичэн</p>	

агаарт физик бохирдол үүсгэх	Ажилчдын ариун цэврийн байгууламж, хаягдал бохир усны цоонгт 1 м ³ бохирт 1л био бэлдмэл байхаар тооцож ариутгал хийх	материалаар барьж байгуулан ашиглаж байна. Уурхайн үйлчилгээний ажилтан ажилчдын ОО, угаалгын өрөө, ахуйн шингэн бохир хаях цооногийн орчмыг 7 хоногт 1 удаа Тамир био ариутгагчаар халдваргүйжүүлэлтийг хийж хэвшсэн.	
---------------------------------	--	---	---

2. Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний биелэлт

Уурхайн сөрөг нөлөөллийн бүсэд орших иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллагыг зайлшгүй нүүлгэх шаардлагатай болсон тохиолдолд тэднийг нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө боловсруулна. Ингэхдээ тэдэнд өгөх нөхөн олговрыг хэдийд өгөх, шинэ газарт нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагааг тэдний саналыг харгалзан хэдийд зохион байгуулахыг тодруулан тусгана. Энэхүү төслийн хувьд иргэд оршин суугчдад үзүүлэх хүчтэй сөрөг нөлөөлөл байхгүй байна.

Хэрэв цаашид нүүлгэн шилжүүлэлт нөхөн олговортой холбоотой асуудал гарвал газар болон бусад үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой өмчлөх, хуваарилах, бэлэглэх, шилжүүлэх үйл явцыг Монгол улсад дараах хууль тогтоомжуудаар зохицуулна. Үүнд:

1. Үндсэн хууль (1992);
2. Газрын тухай хууль (2002);
3. Монгол Улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль (2003);
4. Иргэний тухай хууль (2002) багтана.

3. Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжинд заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ийн Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

4. Нөхөн сэргээх арга хэмжээний төлөвлөгөө


Уурхайн үйл ажиллагаанаас нийт 8.85 га талбай эвдрэлд өртөнө. Нөхөн сэргээлтийн ажлыг уурхайн үйл ажиллагаа эхэлснээс хойш 3 дахь жилээс хийхээр ТЭЗҮ-д тусгагдсан бөгөөд 2022 онд нөхөн сэргээлт хийхгүй.

5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалал хийх аргачлалд зааснаар жижиг төслүүдийн хувьд дүйцүүлэн хамгааллын хамтарсан байдлаар хэрэгжүүлэх боломжтой бөгөөд гагцхүү нөлөөллийн хэмжээг тогтоох шаардлагатай юм. Иймээс тус компани дүйцүүлэн хамгаалал хийх арга хэмжээг

төсөл хэрэгжих талбайн ойролцоох хэсэгт хариуцлагагүй уул уурхайн улмаас эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, биологийн олон янз байдалд эергээр нөлөөлөх байдлаар Налайх дүүргийн холбогдох байгууллагатай хамтран төлөвлөх боломжтой гэж үзэж байна.




Хүснэгт 2. Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Дүйцүүлэн хамгаалах чиглэл	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Биологийн нөхөн сэргээлт	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд нэгдэн мод тарих	Суулгац худалдаж авах Төслийн талбай 200м ² 1000ш Хөрс бэлдэх Арчилгаа хийх	Тэрбум мод үндэсний хөдөлгөөнд нэгдэн 2.5 сая. төгрөгийн хандив тусламж үзүүлсэн. 

6. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Хүснэгт 3. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх бууруулах, арилгах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Осол эрсдэл үүсэх	Ажил эхлэхийн өмнө ажилтан бүрт хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгсний дараа ажил эхлүүлэх Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Уурхайн ажил эхлэхээс өмнө уурхайн дарга ажилчдад хөдөлмөр хамгааллын аюулгүй ажиллагааны зааварчилгааг ажлын нарыдаар өгч тэмдэглэл хөтөлдөг. ХАБЭА-ын ажилтан хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны сургалтыг 7 хоногт 1 удаа тогтмол зохион байгуулдаг. Техникүүдийн үзлэг, оношилгоог цаг тухай бүрд нь хийж, техникийн доголдол, бүрэн бүтэн байдлыг байнга хянадаг бөгөөд тайлант хугацаанд тус ордын үйл ажиллагаатай холбоотойгоор ямар нэгэн доголдол бүртгэгдээгүй болно.

	<p>Тэсэлгээний ажлыг мэргэжлийн үнэмлэхтэй тэсэлгээчин хийх буюу мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлэх</p>		<p>Тэсэлгээний ажил хийгдэх талбайд уурхайн бүс гэсэн анхааруулсан тэмдэг байршуулсан болно. 2022 онд тэсэлгээний ажил хийгдээгүй.</p>
<p>Галын аюулгүй байдал</p>	<p>Галын аюулаас урьдчилан сэргийлэх дүрэм журам боловсруулж мөрдөж ажиллах</p> <p>Гал унтраах хэрэгслийг зохих газруудад байршуулж байнгын бэлэн байлгах, галын аюул гарах болзошгүй газруудад анхааруулах зурагт хуудас, тэмдэг тэмдэглэгээг байршуулах</p>	<p>Галын аюулаас урьдчилан сэргийлэх журам боловсруулан Компанийн удирдлагаар батлуулж, ажилчдын амралтын байранд нүдэнд ил харагдахуйц газар байрлуулан, ажилчдад Аюулгүй ажиллагааны сургалтаар заавар зөвлөмжийг өгдөг.</p> <p>Ажилчдын кемп, хоолны газруудад галын хорыг стандартын дагуу байрлуулан, галын аюулаас урьдчилан сэргийлэх самбар, гал гаргахыг хориглох тэ мдэг тэмдэглэгээг нүдэнд ил харагдахуйц газарт байрлуулсан.</p>	
<p>Химийн бодисын эрсдэл</p>	<p>Химийн бодистой харьцаж буй жолооч, ажилчдыг мэргэжлийн сургалтанд хамруулах, химийн бодисын хор аюулын мэдээлэл, бодистой ажиллах аюулгүй ажиллагааны талаар мэдлэгтэй болгох</p> <p>Ажилчдыг химийн бодистой ажиллах хөдөлмөр хамгааллын хувцас, хэрэгслээр бүрэн хангах, хэрэглэж хэвшүүлэх.</p>	<p>Тэсрэх материалын орц болон химийн бодистой харьцах буюу тээвэрлэх, ашиглах үеийн аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг ХАБЭА-ын хүрээнд боловсруулж ажилчдыг мөрдөж ажиллах талаар Аюулгүй ажиллагааны сургалтаар зөвөлгөө, зааварчилгаа өгдөг бөгөөд ажил гүйцэтгэх үед ажлын нарыдаар танилцуулан гарын үсэг зуруулж ажилладаг.</p> <p>Химийн бодистой харьцах үед ашиглах тусгай хувцас хэрэглэлээр ажилчдыг бүрэн хангасан болно.</p>	

Ажилчдын аюулгүй байдлыг хангах

Болзошгүй аюул ослын үед орон нутгийн эмнэлэг болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах талаар гэрээ байгуулж ажиллаж байна.

Ажиллагсдыг түймэр унтраах арга барилд сургах, гал гарсан тохиолдолд шуурхай унтраах арга хэмжээ авах сургалтанд хамруулж, гарын доорх материалаар хангасан.

Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хангах сургалтанд хамруулж, семинар зохион байгуулсан.



Зураг 3. Яаралтай түргэн тусламжийн арга хэмжээ авах эмийн сан



Зураг 4. Ажлын байран дахь хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны зааварчилгаа, самбарууд

Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа болон галын аюултай тэмцэх талаар

Ашиглалтын тоног төхөөрөмж, техник, ажлын болон ахуйн байр савнууд, шатахуун түгээх цэг нь гал түймрээс хамгаалах хэрэглэлээр хангагдсан.

- ✚ Бүх ажилчид нормын хувцас, хамгаалах хэрэгслийг улиралд тохируулан хэрэглэдэг.
- ✚ Уурхай дээр гарч болзошгүй гал түймрийг урьдчилан сэргийлж, уурхайн даргын тушаалаар галын бүлгэм байгуулж түүний ажиллах журмыг боловсруулан бүх ажилчдад танилцуулж хэвшлээ.
- ✚ Ашиглалтын тоног төхөөрөмж, техник, ажлын болон ахуйн байр, шатахуун түгээх цэг нь гал түймрээс хамгаалсан хэрэглэлээр

хангагдсан.

- ✚ Бүх ажилчид нормын хувцас, хамгаалах хэрэгслийг улиралд тохируулан хэрэглэдэг ба хөдөлмөр хамгааллын зааварчилгааг өдөр бүр өгч хэвшсэн.
- ✚ Машин тоног төхөөрөмжийг тусгай газарт байрлуулсан.

Аюулгүй ажиллагаа

2022 онд уурхайн үйл ажиллагаа ил уурхайн аюулгүй ажиллагааны нэгдсэн дүрмийн дагуу явагдсан.

Уурхайн аюулгүй ажиллагаа нь:

- ✚ Уурхайн хажуу догол, дотоод ба гадаад овоолгуудын тогтворжилтыг хамгаалсан байна.
- ✚ Үйлдвэрийн осол гэмтэлтэй тэмцэх
- ✚ Ил уурхайн агаарын хэт хуурайшилт, тоосжилттой тэмцэх
- ✚ Уурхайн ажлын бус хажуу болон овоолгын гулсалт, нуралтаас болгоомжилж тогтворжилтыг шалгаж хянах.
- ✚ Уурхайд цас, бороо, үерийн уснаас хамгаалах суваг шуудууг татаж ус орж ирэх боломжтой бүх талаас нь хамгаалсан байх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэн аюулгүй ажиллагааг ханган ажиллаа.

Аваар устгах арга хэмжээ

Ашиглалтын технологи, хөрс хуулалт, алт олборлолт, тээвэрлэлтийн технологийн аюулгүй ажиллагаа алдагдах, тодорхой хугацааны сул зогсолтоос болж ашиглагдаагүй удсан мөрөгцөгүүд, гадаад, дотоод овоолгын технологийн үзүүлэлтүүдийн норм, норматив хэмжээ зөрчигдөж, мөрөгцөгөөс хөрс шороо нурах, гулсалт, суулт үүсэх, уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм журам зөрчигдсөний улмаас аваар осол гарч болох үндэслэлтэй. Иймд уурхайн үйл ажиллагаанд дараах зөрчлүүдээс сэргийлэх шаардлагатай байдаг ба бид журмын дагуу сэргийлэн ажиллаж байна. Үүнд:

- ✚ Уурхайн ашиглалтын технологи систем алдагдах
- ✚ Үндсэн хэсэг дэх мөрөгцөгүүдийн нуралт, гулсалт, суулт
- ✚ Шатах тослох материал асгарах
- ✚ Уурхайн хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа зөрчигдөх
- ✚ Уурхай дотор ил гал гарах гэх мэт

7. Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлсэн бөгөөд хээрийн судалгааны үр дүнг тайланд хавсаргав.

Хүснэгт 4. Орчны хяналт, шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлсэн биелэлт

Байгаль орчны бүрэлдэхүүн	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Агаар орчин	Агаарын бохирдуулагч бодис (SO _x , NO _x , TSP гэх мэт)	Уурхай орчмын 3 цэгээс агаарын PM 2.5 болон PM 10 тоосонцорын хэмжилт хийж үр дүнг Монгол Улсын агаарын чанарын стандарт MNS 4585:2016-тай харьцуулахад зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс хэтрээгүй байна.
Усан орчин	Химийн ерөнхий шинжилгээ	Унд ахуйн уснаас холбогдох аргачлалын дагуу дээж авч усны ерөнхий шинжилгээг “Нарт ШУҮН Консалтинг” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв. /Шинжилгээний хариуг хавсаргав./
Хөрсөн бүрхэвч	Ерөнхий химийн шинжилгээ болон хүнд элемент (Cu, Cr, Pb, Cd, As, Zn) Хөрсний эрүүл ахуй	Төслийн талбайд нийт 4 цэгээс хөрсний дээж авч, хөрсний агрохимийн 2 дээжийг 300-500 гр, хүнд металлын 2 дээжийг 200-300 гр хэмжээтэй авсан. Хөрсний агрохимийн болон хүнд металлын шинжилгээг “НАРТ ШУҮН КОНСАЛТИНГ” ХХК-ийн хөрс судлалын итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлэв. /Шинжилгээний хариуг хавсаргав./

8. Байгаль орчныг хамгаалах удирдлага зохион байгуулалт

Хүснэгт 5. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
<p>Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10¹ болон БО-ны ерөнхий үнэлгээний шаардлагын дагуу 2 жил тутамд Байгаль орчны аудит хийлгэх</p>	<p>Байгаль орчны төлөвлөгөөт аудитыг БО-ны аудит хийх тусгай зөвшөөрөлтэй “Ногоон гэрэлт ирээдүй” ХХК-тай гэрээ байгуулсан.</p>
<p>Орон нутгаас тавьсан санал хүсэлтийг харилцан тохиролцож шийдвэрлэж байх</p>	<p>Уурхайн үйл ажиллагааны явцад Налайх дүүргийн 7-р хорооноос гудамж талбай засаж сайжруулах санал ирсэний дагуу үерийн усны улмаас үүссэн гуу жалгыг тэгшилж, сайжруулах ажлыг компанийн зүгээс хүн хүч, техникийн туслалцаа үзүүлэн, шаардлагатай хөрөнгийн зардлыг гаргасан болно.</p> <div data-bbox="797 533 2013 852" data-label="Image"> </div>
<p>Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх</p>	<p>Байгаль орчны мэргэжилтэн ажиллуулж байгаа бөгөөд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх талаар уурхайн ажилчдад тогтмол сургалт зохион байгуулж, зөвлөмж өгч ажиллаж байна</p>
<p>Байгаль хамгаалах талаар хийсэн ажлын жил бүрийн тайланг БОАЖЯ –нд хүргэж өгөх.</p>	<p>2022 оны БОМТ-ний тайланг боловсруулж дууссан. Цахим тайлан илгээх сайтад бүртгүүлж эрхээ нээлгэсэн болно.</p>
<p>Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Байгаль хамгаалахад орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, уулзалт зөвлөгөөг зохион байгуулах, тэдний санал зөвлөмжийг БОХТ-г хэрэгжүүлэх ажилд тусгах</p>	<p>2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгуулах ажлын саналыг Налайх дүүргийн Төрийн захиргааны байгууллага болон орон нутгийн иргэдээс авч тусгасан болно.</p>

9. Олон нийтэд тайлагнах хуваарь, төлөвлөгөөний биелэлт

Оролцогч, сонирхогч талуудад тайлагнах, хэлэлцүүлэх. Сайханы хөндий алтны ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл нь Хэнтий аймгийн Батширээт суманд хэрэгжих тул төслийн үйл ажиллагааны тайлан, мэдээг хамгийн их сонирхогч, оролцогч талууд нь эдгээр сумын удирдлагууд, ард иргэд, оршин суугчид болно. Тиймээс сонирхогчид болон оролцогч талуудад хүргэх мэдээллийг тэдгээрийн сонирхолд нийцсэн хэлбэрээр бэлтгэж, хэлэлцүүлэх, танилцуулах арга хэмжээг хийх шаардлагатай.

БОМТ-г орон нутагт танилцуулах, хэлэлцүүлэх ажлын зардал. Төслийн үйл ажиллагааны хүрээнд байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн ажлын тайлан, мэдээг танилцуулж, хэлэлцүүлэх ажлыг жилд нэг удаа зохион байгуулна.

Хүснэгт 6. БОМТ, түүний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнасан биелэлт

БОМТ хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах, хэлэлцүүлэх хэлбэр	Мэдээллийн агуулга	Хэрэгжүүлсэн арга хэмжээ
Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага	Тайлан хүргүүлж тайлагнах	БОМТ-ний хэрэгжилтийн талаар	2022 оны БОМТ биелэлтийн тайланг боловсруулж дуусан. Цахим тайлан илгээх эрхээ нээлгэсэн болно.
Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга	Танилцуулж, тайлагнах	Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн талаар	БОМТ-г БОАЖЯ-ийн сайдын 2019 оны А/618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу 2022 оны байгаль орчны менежментийн биелэлтийн тайланг Нийслэлийн байгаль орчны газарт хүргүүлсэн. Тус тайланг хянаж, дүгнэх ажлын хэсгийг томилуулах хүсэлт гаргасан.
Төслийн ажилчид ба орон нутгийн иргэдэд	Тайлагнах	Төслийн ажилчид ба орон нутгийн иргэдээс гомдол, санал гарсан тохиолдолд цаг алдалгүй санал гомдлыг нь барагдуулах зорилгоор гомдол барагдуулах менежментийн төлөвлөгөөг тогтвортой хэрэгжүүлэх;	2022 онд орон нутгийн иргэдээс санал гомдол ирээгүй болно.